



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/3/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.05 № 09

танай _____-ны № _____-Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2020.02.05 №09

D: Mv computer – TOOT A4

110519289



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорнод аймгийн Мал хамгаалах сан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч Ж.Алимаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зээлийн авлагыг хүүг тооцох зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал хамгаалах сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 01 дүгээр сарын 31-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй орон нутгийн хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник, технологийн болон эргэлтийн хөрөнгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, зээлийн ашиглалтанд хяналт тавих, зээлийг эргэн төвлөрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх”-д оршино.

Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагаа юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2011 оны 374-р тогтоолоор батлагдсан Мал хамгаалах сангийн журам нь хүчингүй болсон.
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль шинэчлэн батлагдсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Мал хамгаалах сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мал хамгаалах сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Excel программ хангамж ашигладаг байна.

Мал хамгаалах сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мал хамгаалах сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 60000,0 мянган төгрөгөөс тооцон 1200,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 0,4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардал бага гарч авлагыг бүрэн цуглуулж чадаагүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мал хамгаалах сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2352,6 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгө болон авлагын дансанд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	70006,3	116881,7	46875,4
Авлага	107467,0	62944,2	-44522,8
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	177473,3	179825,9	2352,6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Өмнөх үеийн үр дүн	177473,4	177473,4	
Тайлангийн үеийн үр дүн		2352,6	2352,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	177473,3	179825,9	2352,6

Авлага дансны үлдэгдэл буурсан нь зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2012-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 62944,2 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна. Үүнээс шүүхийн шатанд шилжсэн 47559,5 мянган төгрөгийн авлага, шүүхийн шатанд шилжээгүй 15384,7 мянган төгрөгийн авлага байна.

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн нь 179825,9 мянган төгрөг болж 2352,6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тайлант үед ашигтай ажилласан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мал хамгаалах сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд төсвөөс санхүүжилт аваагүй, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник, технологийн болон эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, зээлийн ашиглалтад хяналт тавих, зээлийг эргэн төвлөрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна..

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.



Аудитаар нийт 30,769.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 15,384.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15,384.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 15384,7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 15384,7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8 заалт, АОУС 250 стандарттай нийцэхгүй, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрх зүйн орчны өөрчлөлт хийгдэж, авлагыг бүрэн барагдуулсан эсэхийг анхаарах шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 107467,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөр барагдуулах зөвлөмж өгч 44522,8 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 41,5 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Мал хамгаалах сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Зээлийн авлагаас шүүхийн шатанд шилжээгүй 15,4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд хүү тооцоогүй байна. Энэ нь хамгийн сүүлийн зээл 2015 онд олгогдсон. Нягтлан бодогч 2017 онд ажил хүлээж авахдаа зээл, зээлийн хүүг төлөгдөх хугацаагаар бүрэн тооцож авлагад тусгасан тооцоо хүлээн авсан гэсэн шалтгаанаар гэрээний заалтыг дахин хянаагүй байна.

1.2. Эрсдэл: Авлагын хүүг буруу тооцох

1.3. Өгсөн зөвлөмж: Зээлийн гэрээг хянаж авлагын хүүгийн тооцооллыг хийх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

2. Байгууллагын эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: ЗГ-ын 2011 оны 374-р тогтоолоор батлагдсан Мал хамгаалах сангийн журам нь хүчингүй болсон, ЗГ-ын тусгай сангийн тухай хууль шинэчлэгдэн гарсантай холбоотой мал хамгаалах сангийн хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн гаргаагүй байна.

2.2. Эрсдэл: хүчингүй болсон хууль журмыг хэрэглэх

2.3. Өгсөн зөвлөмж: Эрх зүйн зохицуулалтыг хууль, журмын дагуу хийх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу Засаг дарга болон Сангийн зөвлөлд уламжлан эрх зүйн зохицуулалтыг хийнэ.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	177 473 364,00	179 825 919,00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	70 006 317,29	116 881 654,29
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00,00	00,00
31110	Төгрөг	00,00	00,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	70 006 317,29	116 881 654,29
3121	Төгрөг	70 006 317,29	116 881 654,29
31211	Төрийн сангийн харилцах	70 006 317,29	116 881 654,29
33	АВЛАГА	107 467 046,71	62 944 264,71
336	Зээлийн авлага	107 467 046,71	62 944 264,71
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	107 467 046,71	62 944 264,71
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	107 467 046,71	62 944 264,71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00,00	00,00
391	Газар	00,00	00,00
392	Биет хөрөнгө	00,00	00,00
393	Биет бус хөрөнгө	00,00	00,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	177 473 364,00	179 825 919,00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00,00	00,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00,00	00,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	177 473 364,00	179 825 919,00
51	Засгийн газрын хувь оролцоо	177 473 364,00	179 825 919,00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00,00	00,00
51101	Өмч: - төрийн	00,00	00,00
512	Хуримтлагдсан үр дүн	177 473 364,00	179 825 919,00
51210	Өмнөх үеийн үр дүн	164 916 451,00	177 473 364,00
51220	Тайлант үеийн үр дүн	12 556 913,00	2 352 555,00
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00,00	00,00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00,00	00,00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00,00	00,00
51600	Нөөцийн сан	00,00	00,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	177 473 364,00	179 825 919,00



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	72 556 913,00	11 532 555,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72 556 913,00	11 532 555,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	72 556 913,00	11 532 555,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	00,00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00,00	00,00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	00,00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	72 556 913,00	11 532 555,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	60 000 000,00	9 180 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60 000 000,00	9 180 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60 000 000,00	9 180 000,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60 000 000,00	9 180 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60 000 000,00	9 180 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12 556 913,00	2 352 555,00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	72 556 913,00	11 532 555,00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	00,00	00,00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	60 000 000,00	9 180 000,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	12 556 913,00	2 352 555,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12 556 913,00	2 352 555,00



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	93 960 691,00	56 055 337,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	93 960 691,00	56 055 337,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	93 960 691,00	56 055 337,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	00,00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00,00	00,00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	00,00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	93 960 691,00	56 055 337,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	60 000 000,00	9 180 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60 000 000,00	9 180 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60 000 000,00	9 180 000,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60 000 000,00	9 180 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60 000 000,00	9 000 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00,00	180 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	00,00	00,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33 960 691,00	46 875 337,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	00,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	00,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	00,00
2260	Гадаад эх үүсвэрээр	00,00	00,00
226001	Гадаад эх үүсвэрээр	00,00	00,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	00,00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
14	Бусад эх үүсвэр	00,00	00,00



7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	33 960 691,00	46 875 337,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36 045 626,29	70 006 317,29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70 006 317,29	116 881 654,29

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	164 916 451,00	00,00	164 916 451,00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	164 916 451,00	00,00	164 916 451,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	00,00	00,00	00,00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00	00,00
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	177 473 364,00	00,00	177 473 364,00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00



Мал хамгаалах сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	177 473 364,00	00,00	177 473 364,00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	2 352 555,00	00,00	2 352 555,00
D09	2019 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	00,00	00,00	179 825 919,00	00,00	179 825 919,00